БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ,
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА Г.ЭНХМӨНХ
ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“НУМТ ГҮРЭН”ХХК ЗАХИРАЛ: Ч.ЦЭРЭНЛХАМ

УЛААНБААТАР ХОТ ХАН-УУЛ ДҮҮРЭГ 23-Р ХОРОО АРЦАТЫН АМАНД ОРШИХ “ТЭНЭГЭР УУЛС” ХХК-ИЙН “НУМТ ГҮРЭН” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6358667

ХЯНАСАН:

ХБОБЗГ МЭРГЭЖИЛТЭН:

БОЛОВСРУУЛСАН:

ТЭНЭГЭР УУЛС ХХК-ИЙН

МЭРГЭЖИЛТЭН : М.БАТБИЛЭГ

ГАРЧИГ

ОРШИЛ 2

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА 3

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл 3
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл 3
1.3. Төслийн байршил 3
1.4. Төслийн үйл ажиллагааны үндсэн чиглэл 4
1.5. Төслийн ажиллах горим 4

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ 6

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 9

3.1. Байгаль хамгаалах төлөвлөгөөний зорилго 9
3.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОХТ)-ний ерөнхий үндэслэл 9
3.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 10
3.4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө 12
3.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө 12
3.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 13
3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 14
3.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 15
3.9. Нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө 15

ОРШИЛ

“Тэнгэр Уулс” ХХК-ийн хэрэгжүүлж буй Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, Арцатын аманд байрлах “Нумт Гүрэн” аялал жуулчлалын төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, байгаль орчны төлөв байдлыг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох агаар, ус, хөрс, ургамал, амьтан болон тухайн орчны экосистемд үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлон үнэлж, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, байгаль орчны хяналт-шинжилгээ, мониторингийн ажлыг төлөвлөхөд чиглэгдэнэ.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй тоосжилт, дуу чимээ, ахуйн болон хатуу хог хаягдал, бохир ус, хөрсний элэгдэл, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл зэрэг байгаль орчны асуудлыг харгалзан холбогдох арга хэмжээг тусгасан. Мөн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчны экологийн төлөв байдлыг тогтмол хянах зорилгоор хяналт-шинжилгээ, мониторингийн ажлыг төлөвлөсөн болно.

Тус төлөвлөгөөг хэрэгжүүлснээр “Нумт Гүрэн” аялал жуулчлалын төслийн үйл ажиллагааг байгаль орчны хууль тогтоомж, холбогдох стандарт, норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчны хамгааллын үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм.

Иймд “Тэнгэр Уулс” ХХК нь 2026 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, тэдгээрийн биелэлтэд хяналт тавин ажиллаж, төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарч ажиллана.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч:	“Тэнэгэр Уулс”ХХК
Төслийн нэр:	Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн, түр буудаллах, отоглох, ажиглалт судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах “Нумт гүрэн” аялал жуулчлалын цогцолбор” төсөл
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:	9011641028,
Регистрийн дугаар:	6128459
Төсөл хэрэгжих талбай:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23-р хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар хотын төвөөс 13.4 км зайтай, Богд уулын дархан цаазат газрын хилийн зааг дотор Арцатын амны хязгаарлалтын бүс
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	• Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8-р хороо, Ташгайн ам, Нумт гүрэн ресорт
Төслийн зорилго:	• Үндэснийхээ түүхэн өв соёлыг орчин үеийн эрэлт хэрэгцээтэй ухаалгаар хослуулсан, дөрвөн улирал ажиллах, шинэ өнгө төрөх бүхий аялал жуулчлалын үндэсний брэндийг бий болгон хөгжүүлэхэд төслийн зорилго оршино.

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


“Тэнэгэр уулс” ХХК нь 2018 онд байгуулагдсанаасаа хойш аялал жуулчлалын чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь Үндэснийхээ түүхэн өв соёлыг, орчин үеийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээтэй хослуулж, ногоон хөгжлийг дэмжсэн, өрсөлдөх чадвартай салбартаа тэргүүлэгч аялал жуулчлалын шинэ брэнд болон хөгжих алсын хараатайгаар ажилладаг.

1.3. Төслийн байршил

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23-р хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар хотын төвөөс 13.4 км зайтай, Богд уулын дархан цаазат газрын хилийн зааг дотор Арцатын амны хязгаарлалтын бүсэд үйл ажиллагааг явуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөл бүхий талбайн өнцгүүдийн газар зүйн солбицлууд

№	Уртраг	Өргөрөг	Урт	Цэг
1	106°51'15.13"	47°51'1.52"	0.00	1-2
2	106°51'13.56"	47°50'57.88"	49.19	2-3
3	106°51'15.76"	47°50'57.54"	31.74	3-4
4	106°51'14.42"	47°50'53.32"	21.01	4-5
5	106°51'4.83"	47°50'54.24"	64.05	5-6
6	106°51'9.25"	47°51'3.56"	11.09	6-1



Зураг 1. Төслийн байршил

1.4. Төслийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

Төслийн үйл ажиллагаа нь аялал жуулчлал, амралт, спорт, соёлын арга хэмжээ, зочид буудлын үйлчилгээ зэрэг олон төрлийн үйлчилгээг нэг дор төвлөрүүлсэн цогц бүтэцтэй байна. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, аюулгүй байдал, тав тух, байгаль орчны тогтвортой байдлыг хангах зорилготой. Үндсэн үйл ажиллагаанд дараах үйлчилгээ орно.

- Зочид буудлын үйлчилгээ
- Гэр амралтын үйлчилгээ
- Ивент танхимын үйлчилгээ
- Хурим, баяр ёслолын арга хэмжээ
- Байгууллагын арга хэмжээ, сургалт
- Аялал жуулчлалын хөтөлбөр
- Ресторан, хоол үйлчилгээ
- Соёлын арга хэмжээ

1.5.Төслийн ажиллах горим

Нумт гүрэн аялал жуулчлалын цогцолборын үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй зохион байгуулахын тулд улирлын онцлогт тохирсон аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх төлөвлөгөөтэй ажиллах юм. Монгол орны цаг уур, аялал жуулчлалын улирлын онцлог, хэрэглэгчдийн амралт, аяллын зан төлөвийг харгалзан үйлчилгээний төрөл, арга хэмжээг улирал бүрд ялгаатай байдлаар төлөвлөсөн нь төслийн тогтвортой байлгах чухал хүчин зүйл юм байна.

Хүснэгт 3. Төслийн нийт ажиллах хүч

№	Хэсэг	Орон тооны тоо	Нийт ажилтын тоо
1	Захиргаа, санхүүгийн алба,	16	55
2	Хоол үйлдвэрлэлийн алба	13	

3	Үйлчилгээний алба	26	

Хүснэгт 4. Төслийн нийт ажиллах хүч

№	Алба нэгж/бүтэц	Хариуцах ажлын байр	Албан тушаал	Орон тоо
1	Захиргаа үйл ажиллагааны алба	Оффис	Гүйцэтгэх захирал	1
2			Ерөнхий менежер	1
3			Хүний нөөцийн менежер	1
4			Маркетингийн менежер	1
5			Ивент менежер	2
6			График дизайнер	1
7			Захиалгын мэргэжилтэн	3
8			Цайлгаан, тоног төхөөрмжийн засварчин	1
9			Жолооч/харуул	1
10	Санхүү, бүртгэлийн алба	Оффис, агуулах	Ерөнхий нягтлан бодогч	1
11			Тооцооны нягтлан бодогч	1
12			Нярав	2
13	Үйлчилгээний алба	Оффис, үйлчилгээний барилга. 1-дүгээр давхар (Ресторан, 9 эрдэнийн өргөө, VIP өрөө, зочдын хувцас солих өрөө, өлгүүр, АЦӨ, лобби-хүлээлгийн танхим)	Ээлжийн ахлах	3
14			Заал зохион байгуулагч	3
15			Хөгжим, гэрэлтүүлгийн техникч	2
16			Бармен	3
17			Касс	3
18			Зөөгч	6
19			Угаалгын ажилтан	2
20			Үйлчлэгч	3
21			Талбайн үйлчлэгч, цэрэрлэгч	1
22	Хоол үйлдвэрлэлийн алба	Оффис, үйлчилгээний барилга. 1-дүгээр давхар (Ресторан, 9 эрдэнийн өргөө, VIP өрөө, зочдын хувцас солих өрөө, өлгүүр, АЦӨ, лобби-хүлээлгийн танхим)	Ерөнхий тогооч	1
23			Ахлах тогооч	2
24			Туслах тогооч	4
25			Бэлтгэгч	3
26			Угаагч	3
НИЙТ				**55**

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Газарзүйн онцлог: Газар зүйн нөхцөл, газрын гадаргын хувьд бол Богд Хан Уул зүүнээс баруун тийш чиглэсэн их нуруу болон түүний салбар уулсаас бүрдэнэ. Богд Хан Уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2268 метр өндөрт өргөгдсөн Цэцээ Гүн, 2256 метр өндөрт орших Түшээ гүн хэмээх оргилууд болно. Богд Хан Ууланд 2000 метрээс дээш өргөгдсөн эртний тэгшрэлийн гадарга голлоно.

Геологийн тогтоц: Судалгаанд хамрагдаж байгаа талбайн хувьд гидрогеологи-инженер геологийн нөхцөлийн хувьд дөрөвдөгчийн сэвсгэр хурдас бүхий голын II дэнжид байрлах бөгөөд урьд өмнө судалгааны ажлын хүрээнд өрөмдсөн гидрогеологи-инженер геологийн хайгуулын цооногуудын геологи-литологийн зүсэлтээс үзэхэд элсэн чигжээстэй бул чулуутай сайр хайрга бүхий хөрс чулуулаг нь (голын адаг орчимд) 35-42м зузаантай, элсэн чигжээстэй бул чулуутай сайр сайрган (голын дунд хэсэгт) хөрс чулуулаг нь 5-10м зузаантай, шавар чигжээстэй сайр сайрган хөрс нь (голын дунд хэсэгт) 15-20м зузаантай, харин үндсэн чулуу болох хувирмал чулуулаг (занар, гуранз) нь голын эхэн хэсэгт 20м-ээс, голын адаг хэсэгт 25-38м-ээс эхлэн доош үргэлжилнэ. Харин голын адаг орчимд үндсэн чулуулаг нь нэлээд доороос (50-60м-ээс) ордог байна.

Цэвдэг: Улаанбаатар хотод улирлын ба олон жилийн цэвдэг ул хөрс, чулуулаг тархсан байдаг. Манай орны цэвдэг дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст тархсан олон жилийн цэвдгийн өмнөд хил болдог учраас Сибирийн мөнх цэвдгийг бодвол өндөр температуртай, байгалийн хүчин зүйл болон хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөнд амархан өртөж хувирч өөрчлөгддөг онцлогтой. Ийм учраас тус газарт тархсан улирлын ба олон жилийн цэвдгийг судалж түүний нөлөөнөөс урьдчилан сэргийлж байгаль хамгаалахад цэвдгийн нөхцөлийг зайлшгүй тооцож байх шаардлагатай.

Геоморфологи: Богдхан уул нь Монгол-Агнуурын геосинклиналийн өмнөд хаяа болох Хэнтийн нурууны өмнөд захад орших тул гадаргын хэлбэршил нь эх газрын дотоодын уур амьсгалын хүчин зүйлийн үйлчлэл тодорхой тусгагдсан. Горхи-Тэрэлжийн боржингийн массивын үргэлжлэл, түүний зах төгсгөл хэсэг тул уулын ам хөндийнүүд, бэл хормойн хурдас боржингийн өгөршлийн бүтээгдэхүүн, хэмхдэс болно. Зарим хэсгээр нь занар, хувирмал чанарын илэрц, судал тохиолдох боловч тархалтын хүрээ бага Богдхан уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн гол нуруу, түүний салбар уулсаас бүрдэх ба хамгийн өндөр оргил нь 2268,0 м өргөгдсөн Цэцээ гүн юм.

Тектоник: Газарын хэмжээнд Чулуун нүүрсний галавын үед (350-205 сая жилийн тэртээ) хуримтлагдсан тунамал чулуулаг, Мезозойн эриний Триасын галавын сүүлч, юрийн галав (T3-J1) ын эхээр (130 сая жилийн өмнө) үүсч бүрэлдсэн боржин чулуу, мөн уулын бэл, хормой, гуу жалга орчимд сэвсгэр хурдас тархаж байдаг.

Тогтцын хувьд Богд Хан Уул Хангай, Хэнтийн атираат бүсийн Хэнтийн хэсгийн баруун өмнөд талд оршдог. Богд Хан Уул нь Хэнтийн нурууны ай савд багтах боловч гол нуруунуудаас саланги орших бөгөөд өндрийн болоод уулархаг хотгор гүдгэрийн нөлөөгөөр тэнд ой, тайгын ландшафт голлох байр эзэлж, Монгол орны ойн тархалтын хамгийн өмнөд зах нь болно. Чухамдаа Монгол орны ойт хээр, хуурай хээрийн бүсийн зааг дээр орших босоо бүсшил бүхий уулсын тогтоцтой.

Уур амьсгал: Жилийн дундаж температур -3.5°C, хүйтний улирлын дундаж хэм -27.3°C, дулааны улирлын дундаж хэм -17.1°C. Богдхан уул нь хүйтэн өвөлтэй, сэрүүвтэр

зунтай. Улаанбаатар хот орчмын уур амьсгалын нөхцөлийг судлах ажил 1930 аад оноос эхэлсэн бөгөөд энэ дагууд Богдхан уулын эргэн тойрны гол амнууд болон түүний орчмын зарим газарт цаг уурын станцууд байрлуулж, цаг уурын үзэгдлийг судалж ирсэн байна. Богдхан ууланд жилд дунджаар 2800 цаг нар гийгүүлж, нар гийгүүлэх цагийн сарын нийлбэр нарны өндрөөс хамаарч 12-р сард хамгийн бага 160 цаг, 5-р сард хамгийн их 2900 цаг орчим байна. Газарзүйн байрлал, хотгор, гүдгэрийн онцлогоос шалтгаалан газрын гадарга орчмын салхины горим хэлбэлздэг. Жилийн дундаж салхины хурд 0,9-2,3м/сек, хамгийн их хурд 5 сард ажиглагдах бөгөөд дунджаар 1,2-4 м/сек, хамгийн намуун үе 12-1 дугаар сард дунджаар 0.7-1.4 м/сек байх жишээтэй. Богдхан уулын нутаг дэвсгэрт унах хур тунадасны хэмжээ уулын орой хэсгээр жилд 450 мм орчим, бэл орчимдоо 250 мм болж буурдаг. Хур тунадасны 89.6-93.4 хувь нь дулааны улиралд орно. Цасан бүрхүүл 11-ээс 3-р сар хүртэл үргэлжилнэ. Цасан бүрхүүлийн зузаан 2-3 см, дүн өвлийн үеэр 5-7см

Гадаргын болон газрын доорх ус: Богд Хан Уул нь усзүйн хувьд Умард мөсөн далайн ай савын Туул голын ай савд багтах бөгөөд олон жилийн дундаж урсац нь 100м-ээс илүү бүс нутагт хамаарна. Уулын эргэн тойрны 20 орчим амнаас гол горхи эх авч зарим нь Туул голд, үлдсэн хэсэг нь уулын хаяа, хормой хотгор гүдгэрт хүрч сэвсгэр хурдсанд шурган орно. Уулаас эх авсан голоос 36.2 км урт Түргэний гол, 33.3 км урт Баруун, Зүүн Зуун Модын гол, 32.6 км Хүрхрээ голуудыг нэрлэж болно. Богдхан уул нь ус зүйн хувьд Хойд мөсөн далайн ай савын Туул голын савд багтана. ДЦГ 20 гаруй жижиг гол, 10 гаруй булагтай. Цаг уурын дулааралт хуурайшилтаас үүдэн гол горхи, булаг шанд ширгэж усны нөөц ихээхэн хомсдож байгаа. 2008 оны байдлаар 9 гол, 8 булаг урсаж байна. ДЦГ-ын нутаг дэвсгэрт үйлчилгээ явуулж буй байгууллагууд 38 гүний худаг гарган ашигладаг байна.

Ургамлан нөмрөг: Улаанбаатар хотын нутагт байрлах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Хэнтийн уулын тайгын тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Богдхан ууланд анхны ургамлын ангилалзүйн судалгааг МОХБИБЭ-ийн судалгаагаар 69 овгийн 259 төрлийн 579 зүйл ургамал бүртгэсэн (Ганболд бусад, 1993). 2004 онд ургамалжлын судалгааг шинээр 26 зүйл ургамал бүртгэсэн (Hilbig et all, 2004). Мөн Ө.Энхмаа 75 овгийн 295 төрлийн 746 зүйл ургамалтай (Энхмаа, 2015) 2020 онд Богдхан уулын 11 аманд хийсэн судалгаагаар 63 овгийн 249 төрлийн 522 зүйл ургамал бүртгэсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд Богдхан уулын 20277.7 га бэлчээрийн 13795.45 га буюу 68 % нь цэвэр, 1449.35 га буюу 7.1 % нь чулуутай, 4367 га буюу 21 % нь сөөгтэй, 651 га буюу 3.2% довонтой байна (Богдхан уулын дархан цаазат газрын чанар, төлөв байдлын хянан баталгаа 2007 он). Богдхан уулын бэлчээрийн хянан баталгааны дүнгээс харахад 4556 га буюу 22.4 % нь их талхлагдсан, 2227 га буюу 10.9% нь бохирдсон буюу эвдэрсэн байна. Богдхан уулын ургамлын аймаг дахь ховор, ховордсон, нэн ховор, эдийн засгийн гоц ашигт 46 зүйл ургамлын тархцын судалгааг хийсэн (Энхмаа, 2017).

Хөрс: Төслийн талбайн Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Богдхан уул нь хөрс газарзүйн мужлалаар Хангайн био уур амьсгалын их мужийн хагас чийглэг өндөршлийн бүсчлэл бүхий Хэнтийн Өмнөд тойрогт багтана. Ой, тайгын хөрсний тархалтын доод хил уулын ар хажууд 1500-1600 м-ийн үнэмлэхүй өндрийн түвшинд байдаг бол өвөр хажууд ихэвчлэн 1700-1800 м болж дээшилнэ. Түүнээс гадна хөрсний хэв шинжүүдийн шилжилт ч уулын ар, өвөр хажууд харилцан адилгүй байна. Богд уулын хөрсний тархалт, бүтэц, хөгжилд түүний үнэмлэхүй өндөр, хажуугийн зүг зовхисын ялгаа, чиглэл, газрын хэвгий голлох үүрэгтэй. Тус талбайн аллювийн нугын/аллювийн

нугын давсархаг, хархүрэн/сайр чулуурхаг хархүрэн, нугын цэвдэгт/нугат намгийн цэвдэгт, уулын хархүрэн/уулын нимгэн харшороон, уулын хархүрэн/уулын ойн ширэгт бараан хөрсний ангилалд хамаарч байна. Хөрсний хүнд металлын шинжилгээний үзүүлэлтийг хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS ISO 11466: 2007, MNS 5850:2019)-тэй харьцуулан харахад стандартаас даваагүй буюу стандарт хэмжээнд байна.

Амьтны аймаг: Тус төслийн байршил болох Богдхан ууланд 2014 оны судалгаагаар 52 зүйл хөхтөн (шавж идэштэн 4, сарьсан далавчтан 5, туулай хэлбэртэн 4, мэрэгчтэн 21, махан идэштэн 13, туруутан 5 зүйл) амьтад тархан амьдардаг болохыг шинэчлэн тогтоосон. Монгол орны хөхтөн амьтны зүйлийн бүрэлдэхүүний 37.7%-ийг эзэлж байгаа нь том үзүүлэлт юм. Нийт амьтны аймгийн 40.3%-ийг мэрэгч амьтад, 25%-ийг махан идэшт амьтад, 7.7%-ийг шавж идэштэн, 9.6%-ийг туруутан, 7.7%-ийг туулай хэлбэртэн тус тус эзэлдэг байна.

Түүх, соёлын дурсгалт зүйлс: Тус дүүргийн нутаг дэвсгэрт орших Богд Хан-Уул нь эрт үеэс буюу 1775 оноос эхлэн төрийн тахилгатай болсон дархан цаазат хайрхан бөгөөд ноён оргил Түшээ гүн нь далайн төвшнөөс дээш 2268 метр, Цэцээ гүн нь 2256 метр өндөрт өргөгдсөн байдаг. Богд Хан-Уулын эзлэх талбай нь 40.8 мянган га бөгөөд 33 амнаас нь булаг, гол горхи ундран хөвч ой нь 9 төрлийн мод, 78 төрлийн ан араатан, 420 гаруй зүйлийн цэцэгт болог бутлаг ургамал 45 зүйлийн хөхтөн, 5 зүйлийн хоёр нутагтан 116 зүйлийн жигүүртэн бүхий байгалийн үзэсгэлэнт газар билээ.

Богд Хан-Уулыг тойрсон эртний домогт уул овоо толгод олон бий. Зэндмэнэ толгой, Зайсан толгой, Ар Зайсан, Өвөр Зайсан, Бөхийн овоо, Умаа хум толгой, Сонсголон толгой, Манзуширын хийд, Айдсын даваа, Буянт-Ухаа, Яармагийн дэнж зэрэг газрууд бол тодорхой цаг үеийн үйл явдлын бодит гэрч болсон түүхэн дурсгалт газрууд юм.

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. Байгаль хамгаалах төлөвлөгөөний зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго: “Нумт гүрэн” аялал жуулчлалын цогцолбор төслийн үйл ажиллагааг явуулахдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Хууль тогтоомжийн нийцэл ба стандартчилал: Төслийн бүхий л үе шатанд Монгол Улсын байгаль орчны холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, техникийн зохицуулалт болон MNS стандартын шаардлагуудыг чанд мөрдөж, "Эрх зүйн нийцэл"-ийг бүрэн хангаж ажиллах.
- Сөрөг нөлөөллийг бууруулах менежмент: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний (БОННҮ) тайлангаар тодорхойлсон болзошгүй эрсдэлүүдийг арилгах, сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зөвлөмжүүдийг үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаанд системтэйгээр нэвтрүүлж хэрэгжүүлэх.
- Урьдчилан сэргийлэх ба хамгаалал: Байгаль орчинд үзүүлж болзошгүй шууд болон шууд бус сөрөг нөлөөллийг эрсдэлийн удирдлагын арга зүйгээр урьдчилан тооцож, экосистемийн унаган төрх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, доройтлоос сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Оролцогч талуудын хамтын ажиллагаа: Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага болон нутгийн иргэдтэй нээлттэй, ил тод харилцааг тогтоож, байгаль хамгаалах асуудлаар харилцан мэдээлэл солилцох, санал хүсэлтийг шийдвэр гаргах түвшинд тусгах замаар "Нийгмийн зөвшөөрөл"-ийг баталгаажуулж ажиллах.

3.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОХТ)-ний ерөнхий үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг юм. Үүнд шаардагдах хөрөнгө оруулалт, хугацаа, давтамж, мөрдөх стандарт, дүрэм журмыг нэгтгэн тусгасан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч “Тэнэгэр уулс” ХХК-ийн зүгээс заавал дагаж мөрдөх үүрэг хүлээсэн удирдамж болно.

Төлөвлөлтийн үндэслэл ба хугацаа:

Хуулийн нийцэл: БОХТ-г "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" Монгол Улсын хууль болон БОУАӨЯ-аас ирүүлсэн Ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн боловсруулав.

Хүснэгт 5. 2026 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал

№	Байгаль орчны менежмент төлөвлөгөөний задаргаа	2026 он
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	37,740.0
2	Олон нийтэд тайлагнах хуваарь	-
3	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	1380.0
Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал, мян.төг		**39 120.0**

Хүснэгт 6. Байгаль орчныг менежментийн төлөвлөгөөний нийт зардлын задаргаа

№	Байгаль орчны менежмент төлөвлөгөөний задаргаа	2026 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	5 000.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний зардал	5 240.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	-
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	7 500.0
5	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	1380.0
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал	20 000.0
7	Нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний зардал	-
Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал, мян.төг		**39 120.0**

БОННҮ-д тусгасан 2026 онд 39120мян.төг төлөвлөж орсон. Бид 2026 оны БОМТ-ын зардлаа тухай БОННҮ-д тусгасан зардлаар төлөвлөн оруулсан бөгөөд нийт зардлын 50% болох 19560мян.төг Хан-Уул дүүргийн Нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулсан болно.

3.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Тэнэгэр уулс” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Нумт гүрэн аялал жуулчлалын цогцолбор” төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь ерөнхий үнэлгээгээр “бага” түвшинд тодорхойлогдсон. Гэсэн хэдий ч төслийн үйл ажиллагааны явцад үүсэх ахуйн шингэн болон хатуу хог хаягдал, хөрсний бүрхэвч, ургамлын аймаг, газрын доорх усны нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг арилгах, сааруулах зорилгоор дараах менежментийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 7. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, задаргаа

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	2026	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Хийн хаягдал, Тоосжилт	Төсөл талбайн орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшнийг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах	Төслийн талбайн хэмжээнд	500.0	2000	Жилд 1 удаа	Агаарын тухай хууль,MNS 4585:2007 агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 MNS 5002:2000 хөдөлмөрийн аюулгүй шуугианы норм, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 дуу чимээ-хэвийн норм, түвшний хэмжээ
	Хог хаягдал түр хадгалах цэгийг салхины доорх талд, усны эх үүсвэрээс алслагдсан байршилд, хөрсөнд нөлөөлөхгүй байхаар бетондож нягтруулсан суурьтай, дээвэр болон хашаа бүхий зориулалтын талбайд төлөвлөх, сайжруулалтыг тогтмол хийх	Төслийн талбайн хэмжээнд	3 000.0	1000	2026-2030	
Тоосжилт, хөрсний бохирдол, газрын нөөц бохирдох	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны тайланг хийлгэх	Төслийн хүрээнд	2000		2026	
Талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох	хаяхгүй байх, тогтсон хугацаанд гэрээ хийсэн байгууллагад шилжүүлэх, түр хадгалах сав баглаа боодол, савны битүүмжид байнга хяналт тавьж ажиллах	Хадгалах байр	-	гэрээний зардал тусгагдсан шилжүүлэх, нийлүүлэх зарчмаар зохицуулагдаж байгаа учраас үйл ажиллагааны жил бүрийн зарцалд тусгагдаж явна.		Усны тухай хууль болон холбогдох дүрэм журам, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 20.1.3 Усны тухай хууль болон холбогдох дүрэм журам Ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлэх хаягдал бохир усны ерөнхий шаардлага MNS 6572:2024
Үерийн эрсдэл	Төслийн барилга, байгууламж барих үе шатанд үерийн эрсдэлээс сэргийлэх хамгаалалт байгууламжийг сайн төлөвлөж барих	Төслийн барилга, байгууламж барих үед маш	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	2027-2028	

Нийт зардал, төгрөг	**5 000 000**

3.4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Аялал жуулчлалын төслийн төлөвлөлт болон “Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд төсөл хэрэгжүүлэгч “Тэнэгэр уулс” ХХК нь мод тарих ногоон байгууламжийг бий болгох шаардлагатай. Тус цогцолборын батлагдсан төлөвлөлтөөр 20000м^2 талбайд ногоон байгууламжтай байхаар төлөвлөсөн байна.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн ногоон байгууламж бүхий бий болгохоор зорьж буй талбайд зүлэгжүүлэлт болон мод тарих ажлыг гүйцэтгэнэ. Ургамалжуулах ажлын зардлыг "Үр түүх, мод үржүүлэг, ойжуулалт, ой үржүүлэг, ойн зурвас байгуулах гар ба механикжсан ажлын тарифт үнэлгээ-2"-т тулгуурлан тооцоолсон болно. MNS 5918:2008 стандартад заасны дагуу ойт хээрийн бүсэд нөхөн сэргээлтийн зорилгоор эгнээ хоорондын зайг 5 м, мод хоорондын зайг 5 м байхаар тооцож, 20000 м2 талбайд нийт 500-800 ширхэг суулгац тарьж ургамалжуулах шаардлагатай байна. Үүнээс 2026 онд нийт 160 ширхэг мод тарихаар төлөвлөгдсөн байна.

Хүснэгт 8. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт болон тэрбум мод үндэсний хөтөлбөр 2026 он

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн	**Нөхөн сэргээлтийн арга**	**Арга хэмжээний цар хэмжээ**	**Хэмжих нэгж**	**Тоо хэмжээ**	**Нэгжийн зардал, төг**	**Нийт зардал, төг**	**Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж**	**Баримтлах эрх зүйн баримт бичиг**
Орчны тохижилтыг сайжруулан ногоон байгууламжийн 20000 м2 талбайд нийт 800 ширхэг суулгац тариалан тарималжуулах		Нарс	ш	20	80.0	1 600.0	Жилийн бүрийн 05 сарын 01-10, 10сарын 1-10 хооронд	MNS5914:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. Агротехникийн ажиллагаа MNS5916:2008 арчилгаа, тордлогоо төслийн талбайд - эвдэрсэн газрыг ургамалжуулах , техникийн ерөнхий шаардлага.
		Шинэс	ш	20	80.0	1 600.0		
		Хайлаас	ш	40	8.0	320.0		
		Бургас	ш	40	6.0	240.0		
		Хус	ш	40	12.0	480.0		
		Нийт			4 240.0			
		Мод тарих ажлын хөлс			1 000.0			
Арчилгаа, тордлогоо	Ногоон байгууламжийн усалгаа тайралт, хэлбэржүүлэлт хийх	Төслийн ногоон байгууламж	Жил бүрийн үйл ажиллагааны зардалд тусган ажиллах					
Нийт зардал, төгрөг						**5 240 000**		

3.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тус “Тэнэгэр уулс” ХХК-ийн аялал жуулчлал цогцолбор байгуулах төсөл нь Хан уул дүүргийн 23-р хорооны нутагт дэвсгэрт хэрэгжихээр төлөвлөгдөж байна. Төслийн талбай нь тусгай хамгаалалттай газар нутаг болон бусад газар ашиглагч нарын зөвшөөрөл бүхий газартай давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно.

3.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайд түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай Богд хаан уулын дархан цаазат газрын захиргаанд болон хорооны засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

Хүснэгт 9. Төслийн бүсэд түүх соёлын, шинжлэх ухааны дурсгалт зүйлс илэрсэн үед хамгаалах арга хэмжээ

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал, сая. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төсөл хэрэгжүүлэх үед археологийн ба палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгал өртөж болзошгүй	Олдвор илэрвэл тухайн үед нь орон нутгийн захиргаанд мэдэгдэж холбогдох арга хэмжээ авах	Төслийн талбайд	-	Төсөв зохиож хэрэгжүүлэх	Шаардлагатай үед	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.1, 27.8, 38.3 зэрэг заалтууд

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

№	Ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /мян.төг/	2026	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Аялал жуулчлал цогцолборын үйл ажиллагаа нь бүрэн эхлэх үед гадаад талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг хангалттай байрлуулах, хаягжуулах	Цогцолборын хог хаягдлын менежмент, дүүргийн хот тохижилт,	Ш	500,0	1500.0	2026	Хог хаягдлын тухай хууль, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр, БОАЖ сайдын 2018.11.17 өдрийн а/443 дугаар тушаал энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
		Үйл ажиллагаанаас гарах дахин боловсруулах хог хаягдлыг ангилан ялгаж, боловсруулах компаниудад мөн дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг тухайн чиглэлийн ААН-тэй гэрээ байгуулж шилжүүлэх, нийлүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих		Жилд 1 Удаа	Гэрээний үнийн дүнгээр	-	Жил бүр	
		Хог хаягдлын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журмын дагуу цахимаар болон цаасан хэлбэрээр энгийн, аюултай хог хаягдлын мэдээ тайланг харьяалах нийслэлийн холбогдох албанд хүргүүлэх, тайлан өгч байх		Улирал бүр	Зардал шаардахгүй	-	Жил бүр	
		Хог хаягдлын тогтсон менежменттэй болох , хог хаягдлыг тодорхой хэмжээнд бууруулах зорилт тавих, хаягдлын хэмжээнд тогтмол хяналт тавих		Удаа	Зардал шаардахгүй	Жил бүрийн үйл ажиллагааны зардал тухайн чиглэлийн арга хэмжээнд тодорхой	Сард 1 удаа	
		“Хог хаягдлын менежмент” сэдэвт ажилчдыг чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж, ажилтан бүрийг мэдээллээр хангах	Нийт ажилчин, албан хаагчид	-	Хог хаягдлын менежмент -		Улирал бүр	

						зардал тусгай ажиллах шаардлагатай.		
2	Хоолны органик хаягдал	Хоол үйлдвэрлэлээс гарах хүнсний ногооны хальс, хоолны үлдэгдэл хаягдлыг тусгай хөргүүртэй орчин хадгалах, мөн тухайн хаягдлыг гахайн фермүүдэд болон бордооны үйлдвэрүүдэд ногооны хаягдлыг нийлүүлэхээр байдлаар гэрээ байгуулж ажиллах	Хоол, хүнсний хаягдал	Тонн	Хаягдлын хэмжээнээс шалтгаалах	3000.0	Жил бүр	
3	Барилгын гаралтай аюултай хаягдал	Барилгын ажлын үеийн зарим будаг, лак, хөөс гэх мэт сав баглаа боодлын аюултай хаягдлыг журмын дагуу шаардлага хангасан орчинд түр хадгалж, эрх бүхий ААН тогтсон хугацаанд шилжүүлэх	Барилга, байгууламж барих үед	Тн	Гэрээний үнийн дүнгээр	3000.0	Жилд 2удаа	
Нийт зардал						**7 500 000**		

3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний зардал

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	2026 он	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар: Тоосжилт -Хорт хийнүүд NO_x, SO_2, CO_2	Аялал жуулчлалын цогцолбор, Хог хаягдлын цэг орчим	Жилд 1 удаа	Нийт 4 дээж	200.0*2	400.0	MNS 4585:2016 MNS 4990:2000 Хөдөлмөр аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага MNS 5003:2000
Дуу шуугианы түвшин	Аялал жуулчлалын цогцолбор, авто зогсоолын хэсэг	Жилд 1 удаа	Нийт 6 дээж	30*6	180.0	
Хөрсний чанар Ерөнхий үзүүлэлт	Хог хаягдлын талбай, ногоон байгууламж тай талбай	Жилд 1 удаа	Нийт 4 дээж	60*4	240.0	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2008 Хот суурин газрын хөрсний үнэлгээний үзүүлэлтийн норм MNS 3297-91 Шинжилгээнд сорьц авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298-91 Хөрс. Сорьц авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 2305-94
Хөрсний хүнд метал	Хаягдлын талбай, түгээлтийн зогсоол	Жилд 1 удаа	Нийт 4 дээж	70*4	280.0	
Хөрсний нянгийн үзүүлэлт	Хаягдлын талбай,	Жилд 1 удаа	Нийт 1 дээж	80*1	80.0	
Усны чанарын ерөнхий үзүүлэлт	Унд ахуйн усны шугам, цэвэршүүлэх төхөөрөмжөөс гарах хоол үйлдвэрлэлийн ус	Жилд 1 удаа	Нийт 2 дээж	65*2	130.0	MNS 0900: 2005 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 4943: 2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий
Усны чанарын хүнд метал		Жилд 1 удаа	Нийт 2 дээж	75*2	150.0	
		Жилд 1 удаа	Нийт 2 дээж	50*2	100.0	

Усны чанарын нянгийн үзүүлэлт						шаардлага, MNS (ISO) 5667-10:2001 “Усны чанар.дээж авах. 10-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах заавар
Нийт зардал, төгрөг						**1 380 000**

3.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, төг	Хариуцсан албан тушаалтан
1	Төслийн үйл ажиллагаанд өртөж байгаа талбайн Монгол тарвагыг (Marmot sibirica) сэргээн нутагшуулах ажлыг төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө шинжлэх ухааны академийн биологийн хүрээлэн, амьтны мэргэжлийн байгууллага, тусга хамгаалалтын захиргаатай хамтран тухайн биологийн төрөл зүйл ховордож байгаа бүс нутагт нь сэргээн нутагшуулах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	2026 он	20 000.0	Төслийн удирдлага, төсөл менежер
2	Жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллаах үйлдвэрийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах байгаль орчинтой холбоотой төлөвлөгөө, гэрээ, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн ажиллах	Жил бүрийн 1-р улиралд	Шаардлагагүй	Удирдлага, захиргаа Байгаль орчны мэргэжилтэн
3	Нийслэлийн төр захиргааны болон бусад байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг заасан цаг хугацаанд нь биелүүлэн чанд мөрдөж ажиллах	Жил бүр	-	байгаль орчны мэргэжилтэн
4	Байгаль орчны төлөвлөгөөний дагуу хийгдэж буй ажлын талаар дүүргийн байгаль орчны байцаагч нарт мэдээлж байх	Жил бүр	Шаардлагагүй	Байгаль орчны мэргэжилтэн
	Нийт зардал	**20 000 000**		

3.9. Нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Байгаль хамгаалах төлөвлөгөөг төсөл хэрэгжих хугацааны туршид хэрэгжүүлнэ.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дараах хуваарийг мөрдөх нь зүйтэй.“Тэнэгэр уулс” ХХК нь байгаль орчны төлөв байдалд хийсэн явцын хяналт шинжилгээг үндэслэн тухайн бодит нөхцөл байдалд нийцүүлэн төлөвлөгөөг жил бүр сайжруулан шинэчилж байх үүрэг хүлээнэ.Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн захиргааны байгууллага болох Богдхан уулын Дархан цаазат газрын захиргаа болон нийслэлийн байгаль орчны албатай хамтран ажиллах ба төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тогтоосон хугацаанд тайланг гаргаж мэдээлж байх шаардлагатай. Төлөвлөгөөний хэрэгжилтэд төслийн баг байнга хяналт тавьж ажиллана.

Хүснэгт 12. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Төсөв /мян.төг/
Дүүргийн иргэд, засаг дарга болон иргэдийн хурал	Уулзалт, үзүүлэн танилцуулга	Үйл ажиллагаа болон БОМТ тайлангийн хэрэгжилтийн талаар	Жилд 1-2 удаа	Аялал жуулчлал	23-р хорооны байр	0.0

ХААН БАНК

Огноо/Date: **2026-10-02 16:12:42**

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction Information

Журналын /Journal No: **33207150**

Гүйлгээний дугаар /Poid: **0**

Системийн огноо/System Date: **2026-10-02 16:11:09**

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount		Ханш/Rate
	5131299572	**НУМТ ГҮРЭН**	**19,560,000.00**	**MNT**	**1.00**
Кт	Банкны дугаар/Branch No **MOFUMNUB**	Банкны нэр/Bank Name **ТӨРИЙН САН**			
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number **MN190090 000900013406**	Нэр/Name	**19,560,000.00**	**MNT**	**1.00**

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-ТЭНЭГЭР УУЛС ХХК НУМТ ГҮРЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦО

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны тев/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD